

Удирдах зөвлөлийн 2015 оны
03 сарын 16-ны өдрийн 14-15/03 тоот
тогтоолын гуравдугаар хавсралт

ЭМ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү дүрмээр Эм зүйн Шинжлэх Ухааны Их Сургуулийн (Цаашид ЭЗШУИС гэх) эрх, үүрэг, удирдлага, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилттэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулна.
- 1.2. ЭЗШУИС нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Компаний тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм, Эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 1.3. ЭЗШУИС нь өөрийн бүрэлдэхүүн болон харьяалалын нэгжүүдийн бодлогыг тусгасан дүрмийг боловсруулан Удирдах зөвлөлөөр батлуулж, мөрдөнө.
- 1.4. ЭЗШУИС нь Боловсрол, Эрдэм шинжилгээ, Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус өмчийн хуулийн этгээд байна.
- 1.5. ЭЗШУИС-ийн эрхэм зорилго нь олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн, Эм зүйн салбарт өрсөлдөх чадвартай Боловсрол, Эрдэм шинжилгээ, Үйлдвэрлэлийн цогц тэргүүлэх их сургууль байхад оршино.
- 1.6. ЭЗШУИС-ийн үндсэн зорилт нь иргэдэд төгсөлтийн өмнөх (Бакалавр), төгсөлтийн (Доктор, Магистр), төгсөлтийн дараахь (Мэргэжил дээшлүүлэх) сургалтаар Эм зүйн болон Анагаах ухааны дээд боловсрол, Эрүүл мэндийн эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн дээд боловсрол эзэмшүүлэх, Эм зүйн шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа эрхлэх, Брэнд болон Женерик эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оршино.
- 1.7. ЭЗШУИС нь тогтоосон журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, өөрийн бэлэгдэл (эмблем, туг)-тэй байна.
- 1.8. ЭЗШУИС-ийн удирдлага нь Монгол улсын нийслэлд байрлана.

1.9. ЭЗШУИС-ийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, Сонсголон, цахим шуудан: University @monos.mn, утас: 976-11-70174640. Факс: 976-11-70174640. Тус сургууль нь англи хэлээр дараахь нэртэй байна. University of Pharmaceutical science

ХОЁР. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. ЭЗШУИС-ийн зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, сектор, лаборатори, үйлдвэрийн цех байна. Тэнхим нь мэргэжлийн тодорхой салбараар төрөлжсөн, сургалт, эрдэм шинжилгээ, үйлчилгээг зохион байгуулах, Сектор, лаборатори нь сургалт, судалгаа туршилт зохион бүтээх ажлыг эрхлэх, Үйлдвэрийн цех нь брэнд, женерик эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон мэргэжилтэн дадлагажуулах сургалтын бааз байна.

2.2. ЭЗШУИС нь боловсрол, эрдэм шинжилгээ, үйлдвэр үйлчилгээний чиглэлээр бүрэлдэхүүний болон харьяалалын салбар сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн (төв), эмийн үйлдвэр, номын сан, хэвлэлийн газар, туршилт-дадлага-үйлдвэрлэлийн газар, эмийн сан, музейтэй байна.

2.3. ЭЗШУИС-ийн харьяа байгууллагууд нь бие даасан хуулийн этгээд байна.

2.4. ЭЗШУИС ба харьяалалын байгууллага хоорондын харилцааг тусгай журам, гэрээгээр зохицуулна.

2.5. ЭЗШУИС-ийн бүрэлдэхүүний болон харьяалалын нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг дор дурдсанаар шийдвэрлэнэ.

2.5.1. ЭЗШУИС-ийн харьяа байгууллагыг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Монос группийн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

2.5.2. ЭЗШУИС-ийн бүрэлдэхүүний сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн (төв) байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг ЭЗШУИС-ийн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

2.5.3. ЭЗШУИС-ийн тэнхим, сектор, лаборатори, хэлтэс, алба, төв, бусад нэгж салбарыг байгуулах, өөрчлөх татан буулгах асуудлыг ЭЗШУИС-ийн Захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

2.5.4. ЭЗШУИС-ийн бүрэлдэхүүний болон бүтцийн нэгжүүд нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд, сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг явуулахаар батлагдсан төсвийн хүрээнд санхүүжин, бие даан ажиллаж, ажлынхаа чанар, үр дүнгийн талаар сургуулийн удирдлагын өмнө хариуцлага хүлээнэ.

2.6. ЭЗШУИС-ийн бүрэлдэхүүний сургуулийн захирлуудыг Удирдах зөвлөлийн зөвшөөрлөөр ЭЗШУИС-ийн Захирал томилж чөлөөлнө. ЭЗШУИС-ийн харьяа байгууллагын гүйцэтгэх захирлыг сургуулийн Удирдах зөвлөл томилж, чөлөөлнө.

ГУРАВ. ЭЗШУИС-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. ЭЗШУИС дараах эрх эдэлнэ.

3.1.1. Эрдэм шинжилгээ, боловсрол, туршилт, үйлдвэрлэлийн болон инновацийн ажлынхаа үр дүнг ашиглах, технологи дамжуулах үйл ажиллагаа явуулах;

3.1.2. Дотоод гадаадын болон олон улсын байгууллагатай шинжлэх ухаан, технологи, сургалт, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд хамтран ажиллах, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, зуучлах;

3.1.3. Эрдэм шинжилгээ судалгааны төсөлд оролцох, туршилт, зохион бүтээх ажлын үр дүн болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд мэдээлэх, сурталчлах, худалдан борлуулах;

3.1.4. Суралцагч элсүүлэх, төгсгөх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх;

3.1.5. Их сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, харьяа нэгж байгуулагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай санал боловсруулах;

3.1.6. Дотоод, гадаадын Их сургууль болон олон улсын шинжлэх ухааны байгууллага, нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох, удирдлагад сонгогдох;

3.1.7. Үйл ажиллагааныхаа чиглэлээр судалгааны грант олгох, технологийн инкубатор ажиллуулах, багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, салбарын мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургах болон мэргэшүүлэх сургалт явуулах;

3.1.8. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гадаад, дотоодын байгууллага иргэдтэй хамтран их сургуулийн дэргэд үйл ажиллагааныхаа чиглэлтэй холбоотой сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний түшиц байгууллага, гарааны компани лаборатори, эмнэлэг, дадлагын бааз, туслах аж ахуй нэгж, байгуулах;

3.1.9. Хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

3.2. ЭЗШУИС дор дурьдсан үүрэгтэй байна.

- 3.2.1. Холбогдох салбарын шинжлэх ухаан, боловсрол, технологийн бодлогыг тодорхойлоход туслалцаа, дэмжлэг үзүүлэх;
- 3.2.2. Эрдэм шинжилгээ, сургалт, туршилт, үйлдвэрлэлийн ажлыг шинжлэх ухааны өндөр түвшинд гүйцэтгэх;
- 3.2.3. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх инновацийн ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг авах;

ДӨРӨВ. ЭЗШУИС-ИЙН БҮТЭЦ

4.1. ЭЗШУИС нь бүрэлдэхүүндээ Монос сургууль, Эрдмийн сургууль, Мэргэжил дээшлүүлэх сургууль харьяандаа Эм судлалын хүрээлэн, Эмийн үйлдвэртэй (Монос Фарм ХХК) байна.

ТАВ. ЭЗШУИС-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 5.1. ЭЗШУИС нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд түүнийг үүсгэн байгуулагч байгуулна.
- 5.2. Удирдах зөвлөл нь 5-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- 5.3. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.
- 5.4. Удирдах зөвлөлийн даргыг 3 жилийн хугацаагаар үүсгэн байгуулагчийн саналыг үндэслэн сонгоно.
- 5.5. Удирдах зөвлөлийн дарга нь хууль тогтоомжийг зөрчсөн нь нотлогдсон эсхүл огцрох хүсэлтээ гаргасан тохиолдолд түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 5.6. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд гишүүдийн 50-аас дээш хувь нь оролцсон тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Удирдах зөвлөлийн хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- 5.7. Удирдах зөвлөлийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэр гаргана;

- 5.7.1. ЭЗШУИС-ийн Захирал,бүрэлдэхүүний болон харьяа байгууллагын Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;
- 5.7.2. ЭЗШУИС-ийн бүрэлдэхүүний болон харьяа байгууллагын дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 5.7.3. ЭЗШУИС-ийн зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны төсвийг батлах;
- 5.7.4. ЭЗШУИС-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;
- 5.7.5. ЭЗШУИС-ийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж мөрдүүлэх;
- 5.7.6. Удирдах зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтөлнө. Хуралдааны тэмдэглэлд хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зөрчилтэй холбогдсон тайлбар, гарах шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ. Гишүүн тайлбараа бичгээр гаргана.

ЗУРГАА. ЭЗШУИС-ИЙН ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

- 6.1. Суралт, эрдэм шинжилгээ, технологийн бодлого, хөтөлбөр, үйлдвэрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах;
- 6.2. Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, бусад журам, түүний биелэлтийг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах;
- 6.3. Бүрэлдэхүүний нэгжийн удирдлагын тайлан, ажлын үр дүнг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах;
- 6.4. Багш, ажилтан, суралцагчийг төрийн дээд болон бусад шагналд дэвшүүлэх;
- 6.5. ЭЗШУИС-ийн Удирдах зөвлөл болон дээд байгууллагад тавих захирлын тайлан, шийдвэрлүүлэх асуудлыг хэлэлцэх;
- 6.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг;

ДОЛОО. ЭЗШУИС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ

7.1. ЭЗШУИС нь сургалт-эрдэм шинжилгээний болон үйлдвэрлэлийн ажлын чиглэлийг тогтоож, түүний онол-арга зүйн түвшин, үр дүнг хэлэлцэж санал дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх зэргээр сургалтын арга зүй, эрдэм судлалын ажлыг мэргэжлийн ерөнхий удирдлагаар хангах, ЭЗШУИС-ийн хүндэт цол, эрдмийн цол өгөх асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий Эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөл нь дүрэмтэй байна.

7.2. Эрдмийн зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

7.3. Эрдмийн зөвлөлийг их сургуулийн Захирал эсхүл Удирдах зөвлөлөөс томилсон эрдэмтэн даргалах бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Удирдах зөвлөл батална.

7.4. ЭЗШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр буюу түүнээс дээш хувь нь оролцсон тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар дор дурьдсан асуудлыг хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэр гаргана.

7.4.1. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг шүүн хэлэлцэж, эрдмийн цол, зэрэг олгох;

7.4.2. Эрдэм шинжилгээ, сургалт, туршилт, зохион бүтээх болон үйлдвэрлэлийн технологийн ажлын шинжлэх ухааны түвшин, үр дүнгийн чанар, явцын байдал;

7.4.3. Сургуулийн бүтэц, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэх, Эрдэм шинжилгээний ажилтан, багш нарын үйл ажиллагаа, тэдний мэдлэг, дадлага, хандлага, ажилтан, ажилчдын ур чадварын түвшинд үнэлэлт өгөх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, боловсролын цол, шагнал, урамшилд тодорхойлох асуудал;

НАЙМ. ЭЗШУИС-ИЙН УДИРДЛАГА

8.1. ЭЗШУИС-ийн өдөр тутмын ажлыг Захирал удирдах бөгөөд Захирлын удирдлага дор үйл ажиллагааны чиглэл хариуцсан дэд захирлууд ажиллана.

8.2. Дэд захирал нь бүрэлдэхүүний болон харьяа байгууллагын Гүйцэтгэх захирлыг хавсран болон хослон ажиллаж болно.

8.3. ЭЗШУИС-ийн Захирал, харьяа байгууллагын гүйцэтгэх захирлууд эрхийнхээ хүрээнд тушаал, шийдвэр гаргана.

ЕС. ЭЗШУИС-ИЙН ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 9.1. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах ерөнхий менежерийн бүрэн эрхийг хуулийн дагуу хэрэгжүүлэх;
- 9.2. Эм зүйн болон анагаахын дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, төрийн бодлогод нийцүүлэн боловсруулсан сургуулийн хөгжлийн чиглэл, хөтөлбөр, түүнчлэн харьяалалын болон бүрэлдэхүүний нэгж байгуулах, татан буулгах, бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх саналаа Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл, Үүсгэн байгуулагчид тавьж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 9.3. Бүрэлдэхүүн сургуулийн багш, ажилтны ажлын байрны тодорхойлолтыг хянан батлах;
- 9.4. Бүрэлдэхүүн сургуулийн багш, ажилтныг ажилд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, ажлаас чөлөөлөх буюу халах;
- 9.5. Үйл ажиллагааныхаа тайланг Удирдах зөвлөл болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмнө тавих;
- 9.6. ЭЗШУИС-ийн гадаад харилцааг өргөжүүлж, бусад орны их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 9.7. Багш, ажилтны цалин, урамшуулалын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- 9.8. Бүрэлдэхүүн, харьяаллын нэгжийг хэвийн, тогтвортой ажиллах нэгдсэн зохицуулалт удирдлагаар хангах, тэдгээрийн үйл ажиллагааны чанарын талаар байнгын бүрэн мэдээлэлтэй байж, үр дүнг хариуцах;
- 9.9. Суралцагчдын суралцах, амьдрах таатай орчин, нийгмийн үйлчилгээнд хамрагдах нөхцлийг бүрдүүлэх, төгсөгчдөд ажлын байр олоход чиглэсэн үйлчилгээ үзүүлэх;
- 9.10. Суралцагчдыг амжилттай суралцах боломж бүрдүүлэх;
- 9.11. Суралцагчдад дадлага хийх, мэргэжлийн туршлага эзэмших, ажлын байр олоход нь дэмжих үйлчилгээ үзүүлэх;
- 9.12. Багш, эрдэм шинжилгээний ажилтны үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдүүлж, тэднийг хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 9.13. ЭЗШУИС-ийн хөгжлийг дэмжих орчин бүрдүүлэх, төгсөгч, дэмжигчдийг татах үйл ажиллагаа явуулах, хамтран ажиллах;

- 9.14. Багш, ажилтны үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдүүлж, тэднийг хөгжүүлэх, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд зуучлан туслах;
- 9.15. Сургуулийг хөгжүүлэх санхүү, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- 9.16. Иргэдийн боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх зэргээр их сургуулийн нийгмийн үйлчилгээг өргөжүүлэх;
- 9.17. ЭЗШУИС-ийн багшийн мэргэжлийн ёс зүйн дүрэм болон бусад журам заавруудыг баталж, мөрдүүлэх;
- 9.18. ЭЗШУИС-ийн бүрэлдэхүүний сургуулийн удирдлагын тайланг сонсож, ажлын үр дүнд үнэлгээ өгөх;
- 9.19. ЭЗШУИС-ийн захирал бүрэлдэхүүн сургуулиудын хэмжээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь холбогдох асуудлаар захиргааны шийдвэр гаргахад зөвлөгөө өгөх, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй Захиргааны зөвлөлийг дэргэдээ ажиллуулна. Захиргааны зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг зохицуулах журамтай байна.
- 9.20. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг;
- 9.21. Боловсрол эрхэлсэн дэд захирал бөгөөд Монос сургуулийн захирлын чиг үүрэг:
- 9.21.1. Сургуулийн бүх түвшний сургалтын бодлого, төлөвлөлт, хяналтын ажлыг удирдах, зохион байгуулах;
- 9.21.2. Сургалтын агуулга, технологи, арга зүйг олон улсын жишигт нийцүүлэх бодлого боловсруулах;
- 9.21.3. Сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр шинээр буй болгох, шинэчлэх, батлах, өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;
- 9.21.4. Багш бэлтгэх, сонгон шалгаруулах, багшийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, багш, хичээлийн туслах ажилтан, тэнхимийн эрхлэгчийн ажлыг дүгнэх, аттестатчилахтай холбоотой харилцааг нэгдсэн удирдлагаар хангах;
- 9.21.5. Багш нарын сургалтын цагийн ачааллыг хянаж, багшийн зохистой орон тоог хангах;
- 9.21.6. Сургалтын ажлыг сайжруулах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, магадлан итгэмжлэл, сургалтын дотоод чанарын удирдлагын асуудлыг хариуцан зохицуулах;
- 9.21.7. Суралцагчийн бие даасан үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг удирдлагаар хангах, хянах;

- 9.21.8. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих;
- 9.21.9. Суралцагчийн мэдлэг чадварыг дүгнэх, энэ үйл ажиллагаанд орчин үеийн техник хэрэгсэл, арга ашиглах асуудлыг удирдан зохион байгуулах;
- 9.21.10. Элсэлт, төгсөлтийн ажлыг удирлагаар хангаж зохион байгуулах;
- 9.21.11. Сургалтын үйл ажиллагааг дэмжсэн таатай орчин бүрдүүлэх, ном, мэдээллийн хангамжийг сайжруулах бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 9.21.12. Сургалтад мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлэх;
- 9.21.13. Сургалтын холбогдолтой мэдээллийн сан бүрдүүлэх;
- 9.21.14. Албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүрэг.
- 9.22. Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал бөгөөд Эм судлалын хүрээлэнгийн захирлын чиг үүрэг:
- 9.22.1. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого, гадаадын тэргүүлэх их сургуулиудын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сургуулийн эрдэм судлалын ажлыг хөгжүүлэх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлого, чиглэл боловсруулах;
- 9.22.2. Эрдэм шинжилгээний ажлын үнэлгээний шалгуурыг сайжруулах, хэрэгжилтийг хангах;
- 9.22.3. Эм зүйн ухааны тухайн салбарыг тэргүүлэн ажиллах өндөр зэрэглэлийн эрдэмтэдийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- 9.22.4. Сургуулийнхаа өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх;
- 9.22.5. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын орчинг бэхжүүлэх, өргөтгөх, шинэчлэх;
- 9.22.6. Эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- 9.22.7. Судалгаа, сургалтын болон үйлдвэрлэлийн ажлын нэгдэлийг хангах;
- 9.22.8. Багш, оюутан, магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлыг дэмжин хөгжүүлэх;
- 9.22.9. Багш нарыг эрдэмшүүлэх, сургуулийн эрдэм шинжилгээний чадамжийг нэмэгдүүлэх;
- 9.22.10. Шинжлэх ухаан, технологийн төсөл, инновацийн төсөл, гэрээт эрдэм шинжилгээний ажил хэрэгжүүлэх асуудлыг удирдлага, зохицуулалтаар хангах;

9.22.11. Шинжлэх ухааны ололт, шинэ мэдлэгийг нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг санаачлан зохион байгуулах;

9.22.12. Сургуулийн эрдэм шинжилгээний ажил, сургалтыг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох, хөгжүүлэх;

9.22.13. Гадаадын их сургууль, олон улсын байгууллагатай хамтарсан судалгаа хийх, төсөл хөтөлбөр боловсруулах, эрдэм шинжилгээний ажилтан, багш солилцох;

9.22.14. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, семинар симпозиум, чуулга уулзалт зохион байгуулах;

9.23. Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд Моносфарм ХХК-ы захирлын чиг үүрэг:

9.23.1. Сургуулийн харъяа Эмийн үйлдвэрийн бодлого, стратеги боловсруулж холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.23.2. Үйлдвэрийн төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлаар санал боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулах, хэрэгжилтийг хангах;

9.23.3. Үйлдвэрийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

9.23.4. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэгдсэн хангамж, сайжруулах бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;

9.23.5. Хэвлэх үйлдвэр, оюутны дотуур байр, эмч /эмнэлэг/-ийн салбар, сургалтын баазын үйл ажиллагаа, санхүү, аж ахуйн үйлчилгээний ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

9.23.6. Ажлын байрны хөдөлмөр эрүүл ахуйн хэвийн нөхцөл, хүнд хортой нөхцөлд ажиллаж буй хүмүүсийн хөдөлмөр хамгаалалтыг хангуулах;

9.23.7. Албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүрэг:

9.24. Уламжлалт анагаах ухааны сургуулийн захирлын чиг үүрэг:

9.24.1. Сургуулийн бүх түвшний сургалтын бодлого, төлөвлөлт, хяналтын ажлыг удирдах, зохион байгуулах;

9.24.2. Сургалтын агуулга, технологи, арга зүйг олон улсын жишигт нийцүүлэх бодлого боловсруулах;

9.24.3. Сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр шинээр буй болгох, шинэчлэх, батлах, өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах;

9.24.4. Уламжлалт анагаах ухааны сургуулийн цаашдын хөгжлийн стратеги бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх

9.24.5. Албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүрэг

9.25. Эрдмийн сургуулийн захирлын чиг үүрэг:

9.25.1. Сургуулийн эрдэм шинжигээний ажлын нэгдсэн бодлогыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэхэд оролцох;

9.25.2. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого, гадаадын тэргүүлэх их сургуулиудын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн бүрэлдэхүүн сургуулийн эрдэм судлалын ажлыг хөгжүүлэх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлого, чиглэл боловсруулах;

9.25.3. Эрдэм шинжилгээний ажлын үнэлгээний шалгуурыг сайжруулах, хэрэгжилтийг хангах;

9.25.4. Эм зүйн ухааны тухайн салбарыг тэргүүлэн ажиллах өндөр зэрэглэлийн эрдэмтэн багш нарын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

9.25.5. Сургуулийнхаа өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх;

9.25.6. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын орчинг бэхжүүлэх, өргөтгөх, шинэчлэх;

9.25.7. Багш, оюутан, магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлыг дэмжин хөгжүүлэх;

9.25.8. Багш нарыг эрдэмшүүлэх, сургуулийн эрдэм шинжилгээний чадамжийг нэмэгдүүлэх;

9.25.9. Шинжлэх ухаан, технологийн төсөл, инновацийн төсөл, гэрээт эрдэм шинжилгээний ажил хэрэгжүүлэх асуудлыг удирдлага, зохицуулалтаар хангах;

9.25.10. Сургуулийн гадаад харилцааны ажлыг удирдах, зохицуулах;

9.25.11. Сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох, хөгжүүлэх;

9.25.12. Гадаадын их сургууль, олон улсын байгууллагатай хамтарсан судалгаа хийх, төсөл хөтөлбөр боловсруулах, эрдэм шинжилгээний ажилтан, багш, оюутан солилцох;

9.25.13. Улс, салбарын , сургуулийн хэмжээнд болон олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, семинар симпозиум, чуулга уулзалт зохион байгуулах;

9.26. Мэргэжил дээшлүүлэх сургуулийн захирлын чиг үүрэг:

9.26.1. Мэргэжил дээшлүүлэх сургалтын үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, багш, ажилтан, оюутны мэргэжлийн мэдлэг, ур чадварт тавих шаардлага, хэрэгжилтийг зохицуулах;

9.26.2. Гадаадын болон дотоодын их дээд сургуулийн эрдэм шинжилгээ, инновацын хэлтэс, Технологи дамжуулах төвтэй хамтран оюутны эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, сургалт-судалгааны нэгдлийг хангах;

9.26.3. Сургалтын хөтөлбөр шинээр нээх, хаах, суралцагч элсүүлэх, кредит цагийн биелэлт, чанарт хяналт тавих;

9.26.4. Суралцагчидад зориулж мэдээллийн орчин бүрдүүлэх;

9.26.5. МДС-ийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллах;

9.26.6. ЭЗШҮИС-ийн хэмжээнд мэргэжил дээшлүүлэх сургалтын санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавьж, үнэлгээ хийх

9.27. Тэнхим, сектор, нэгжийн эрхлэгчийн чиг үүрэг:

9.27.1. Хариуцсан ажлын хүрээнд ажлын үр дүн чанарт байнгын дүн шинжилгээ, хяналт тавьж, өөрийн үнэлгээ хийх;

9.27.2. Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, нийгмийн захиалгад нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, зохих журмын дагуу тэнхимийн сургалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах;

9.27.3. Сургалт, эрдэм судлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан бүрдүүлэх;

9.27.4. Үйлдвэрлэлийн дадлага, төсөлт ажил, дипломын болон магистр, докторын ажлыг явц, суралцагчийн мэдлэг, чадварыг дүгнэх үйл ажиллагааг зохион байгуулах;

9.27.5. Тэнхим, секторын ажилтнуудын сургалт, судалгаа, заах аргын болон бусад ур чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх;

9.27.6. Эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөний дагуу тэнхим, секторын судалгаа-шинжилгээний ажлын нэгдлийг хангах, үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх;

9.27.7. Сургалт, эрдэм шинжилгээний ажлын орчин нөхцлийг тасралтгүй бүрдүүлэх, сайжруулах;

9.27.8. Багш, эрдэм шинжилгээний ажилтан, ажилчдыг сонгон шалгаруулах, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;

9.27.9. Ажлын үр бүтээлийг үнэлэх;

АРАВ. ЭЗШУИС-ИЙН БАГШ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН, АЖИЛЧИД

10.1. Багш, ажилтан нь Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу тухайн албан тушаал (ажлын байрын тодорхойлолт)-д хамаарах ажил үүргийг Захирал буюу түүний эрх олгосон этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

10.2. ЭЗШУИС-ийн багш, эрдэм шинжилгээний ажилтан нь тухайн салбараар мэргэшсэн магистраас доошгүй зэрэгтэй байна.

10.3. ЭЗШУИС-ийн орон тооны багшийн албан тушаал нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлтэй, эрдэм шинжилгээний ажилтан нь тэргүүлэх ажилтан, ахлах ажилтан, дэд ажилтан, дадлагажигч ажилтан гэсэн зэрэг дэвтэй байна.

10.4. Багш, эрдэм шинжилгээний ажилтны ажлын сул орон тоог нийтэд зарлаж, сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгож авна. Мэргэжлийн салбартаа тэргүүлэх эрдэмтнийг урилгаар авч ажиллуулж болно.

10.5. ЭЗШУИС-ийн багш, эрдэм шинжилгээний ажилтан Монгол Улсын Боловсролын тухай хууль болон Шинжлэх ухаан, Технологийн тухай хууль тогтоомжид зааснаас гадна дараах эрх эдэлнэ:

10.5.1. Сургалт, эрдэм шинжилгээ явуулахад шаардагдах мэдээллээр хангагдах;

10.5.2. Төрөл бүрийн хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг туслалцаа авах;

10.5.3. Зохих болзлыг биелүүлэн ЭЗШУИС-ийн профессор, дэд профессор цол хүртэх;

10.6. ЭЗШУИС-ийн багш, эрдэм шинжилгээний ажилтан Монгол Улсын Боловсролын тухай Шинжлэх ухаан, технологийн тухай хууль тогтоомжид зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ.

10.6.1. ЭЗШУИС-ийн дүрэм, журмыг дагаж мөрдөх;

10.6.2. Удирдлагаас даалгасан хуульд нийцсэн бөгөөд ажил үүргийн хуваарьт нь хамаарах ажил үүргийг биелүүлэх;

- 10.6.3. Эрдэм шинжилгээний ажлыг шинжлэх ухааны өндөр түвшинд эрхлэх;
- 10.6.4. Сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээний ажлын арга, аргачлал суралцагчдын бие даан сурах хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, гарын авлага бичих, боловсруулах;
- 10.6.5. Суралцагчдад бие даан суралцах чадвар эзмшүүлэхэд чиглэгдсэн идэвхтэй сургалт явуулах;
- 10.6.6. Оюутныг иргэний өндөр соёлтой бие хүн болж төлөвшихэд нь туслах;
- 10.6.7. Харилцааны болон хариуцлагын өндөр соёлтой байж, багш, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахих;
- 10.7. Багшийн албан тушаалд болон Эрдэм шинжилгээний ажилтанд тавигдах шаардлага, гүйцэтгэх сургалт, судалгаа, нийтэд үйлчлэх ажлын ачааллын хэмжээ ба түүнийг тооцох журмыг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн тогтооно.
- 10.8. ЭЗШУИС-ийн багш, эрдэм шинжилгээний ажилтныг аттестатчилах журмыг Захирлын тушаалаар батална. Багш, Эрдэм шинжилгээний ажилтаныг 3 жил тутам аттестатчилна.
- 10.9. Захиргаа аж ахуй, инженер-техник, үйлдвэрлэл-үйлчилгээ болон сургалт, судалгааны туслах ажилтан, бусад ажилтны эрх үүргийг Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, сургуулийн дотоод журам, албан тушаалын ажлын байрны тодорхойлолтоор тогтооно.

АРВАН НЭГ. ЭЗШУИС-ИЙН СУРАЛЦАГЧИД

- 11.1. ЭЗШУИС нь Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг яс үндэс, гарал үүсэл, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдлыг харгалзахгүйгэр зохих хууль тогтоомжийн дагуу элсүүлэн суралцуулна.
- 11.2. Оюутан, магистрант, докторант (цаашид “суралцагчид” гэнэ)-ыг элсүүлэх, сургах, төгсгөх асуудлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн ЭЗШУИС-ийн Захирлын баталсан журмаар зохицуулна.
- 11.3. Суралцагчид нь Монгол Улсын боловсролын хууль болон бусад хууль тогтоомж, ЭЗШУИС-ийн дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг биелүүлэхээс гадна мэдээллээр хангагдах, сургуулийн удирдах зөвлөлд төлөөлөлтэй байх, сургалтын

төлөвлөгөөний хүрээнд хичээлийг сонгон судлах, амжилттай суралцсаны тэтгэлэг, дэмжлэг авах, өөрийн ахуй амьдрал, сургалттай холбоотой асуудлаар холбогдох байгууллагад санал хүсэлт тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

11.4. ЭЗШУИС-ийн сургалт төлбөртэй байх ба суралцагчид зохих журмын дагуу сургалтын төлбөрийн тэтгэлэг авах, хөнгөлөлт эдлэх эрхтэй;

11.5. Суралцагчдыг элсүүлэх, шилжүүлэн авах, хасах, улируулах, чөлөө олгох, төгсгөх тухай шийдвэрийг ЭЗШУИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна;

11.6. Өөр сургуулиас ЭЗШУИС-д шилжин сурах оюутны багц цагийг хүлээн зөвшөөрөх журмыг сургуулийн сургалтын холбогдох журамд тусгана;

11.7. ЭЗШУИС оюутны өөрийн удирдлагын байгууллага-оюутны холбоо, зөвлөлтэй байна;

11.8. Оюутны холбоо, зөвлөл нь энэхүү дүрэм болон холбогдох хуульд нийцүүлэн баталсан ажиллагаа явуулна. Оюутны холбоо, зөвлөлийн дүрэмд зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагаа, оюутны холбоо, зөвлөлд сонгогдох зарчим зэргийг тусгана;

11.9. Оюутны холбоо, зөвлөлийн дүрмийг сургуулийн захирал батална;

11.10. ЭЗШУИС оюутны холбоо, зөвлөлийн үйл ажиллагаа явуулах, үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай зардлыг санхүүжүүлнэ.

11.11. Суралцагчид нь ёс зүйн дүрэмтэй байна.

АРВАН ХОЁР. ЭЗШУИС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

12.1. ЭЗШУИС нь дараах эх үүсвэрээс санхүүжинэ.

12.1.1. Үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;

12.1.2. Нэг сурагчид ногдох хувьсах зардлын төсвөөс санхүүжүүлэх хэсэг;

12.1.3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтэд зориулсан хөрөнгө;

12.1.4. Сургалтын төлбөр;

12.1.5. Инновацийн төсөл, Шинжлэх ухаан, Технологийн төсөл, гэрээт ажил, үйлчилгээ, аж ахуй бусад үйл ажиллагаанаас олсон орлого;

12.1.6. Аж ахуйн нэгжээс эдийн засгийн сонирхолгүйгээр шилжүүлсэн хөрөнгийг эргэлтэд оруулсанаас олсон орлого;

12.1.7. Аж ахуй нэгж, байгууллага, иргэний хандив, тусламж бэлэг;

12.1.8. Зээлийн хөрөнгө;

12.1.9. Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр;

АРВАН ГУРАВ. ЭЗШУИС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГА

13.1. ЭЗШУИС нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна;

13.2. ЭЗШУИС нь орлогоосоо ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх зэргийг хориглоно;

13.3. ЭЗШУИС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, ажилтнууд тухайн байгууллагын эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно;

13.4. ЭЗШУИС нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль, нам, нэр дэвшигчидэд эд хөрөнгө, хандив өгөхийг хориглоно;

АРВАН ДӨРӨВ. ЭЗШУИС-ИЙН ТАЙЛАН

14.1. ЭЗШУИС нь зохих журмын дагуу жилийнхээ тайлан тэнцлийг гаргаж Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон үүсгэн байгуулагчид тогтоосон хугацаанд өгнө;

14.2. ЭЗШУИС нь үйл ажиллагааныхаа тайланг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үүсгэн байгуулагчид тогтоосон хугацаанд гаргаж өгөх бөгөөд сургуулийн удирдах зөвлөлд хичээлийн жилийн хагас бүтэн жилийн тайланг хэлэлцүүлнэ.

АРВАН ТАВ. ЭЗШУИС-ИЙГ ТАТАН БУУЛГАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ

15.1. ЭЗШУИС -ийг татан буулгах шийдвэрийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрсөнөөр суралцагчийн эрх ашгийг хохироохгүйгээр Үүсгэн байгуулагч шийдвэрлэнэ.

15.2. Үүсгэн байгуулагч 13.1-д заасан шийдвэрээ 21 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.